



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот

┌ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ┐
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК актив хорин ес” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус компанийн гаргаж буй ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх эцсийн хугацаанаас багагүй хугацаагаар олгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн эрхлэх үйл ажиллагааны төрөл болон оноосон нэрд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор мэдэгдэхийг “МИК актив хорин ес” ХХК (Б.Энхсаруул)-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байгаатай холбогдуулан “МИК актив хорин ес” ХХК (Б.Энхсаруул) болон “МИК ОССК” ХХК (Б.Гантулга)-д дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай:

1/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН